



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.03.28 № А-1/1352  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тендерийн шалгаруулалтын тухай

Тус газраас 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зарласан ТХААГ/20240502001 дугаартай “Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний гол нэрийн түүхий эд, бүтээгдэхүүн ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
Энэхүү тендерт оролцож байгаа үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага нь HACCP, ISO22000 хүнсний аюулгүй байдлын стандарт хангасан байх шаардлага нэмэгдүүлж, өөрчилж өгнө үү.	HACCP, ISO22000 хүнсний аюулгүй байдлын стандарт нь олон улсын стандартын шаардлага тул тус шаардлагыг хангах дотоодын аж ахуйн нэгжүүд тендерт оролцох боломжийг хязгаарлана гэж үзээд “Мал эмнэлгийн нэгдсэн систем /certificate.mahis.gov.mn/-д бүртгэлтэй эсэхийг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан тодорхойлолт ирүүлэх” шаардлагыг хэвээр үлдээж байна. HACCP, ISO22000 хүнсний аюулгүй байдлын стандарт хангасан үйлдвэр, аж ахуй нэгж тус тендерт оролцох боломж нээлттэй болохыг мэдэгдье.
Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд мах нийлүүлэх ерөнхий гэрээ байгуулах тендерийг зохион байгуулж өгнө үү.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна” гэж заасны дагуу цахим дэлгүүрт байршсан ижил төрлийн бараанаас цэцэрлэг, сургууль захиалга хийх боломж нээлттэй байна.
Тендерт шалгарсан үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага нь 7 хоног бүх цахим дэлгүүрт үнээ шинэчилж хамгийн хямд үнэтэй байгууллагыг сонгож байгаа. Гэтэл үхэр, хонины шулсан махны тааз үнэ нь зах зээл дээрх үнээс хэт доогуур байгаа тул махны компаниуд энэ багцад оролцох боломжгүй байна. Иймд үхэр, хонины махны тааз үнийг өөрчлөлт оруулж өгнө үү.	Тус газраас 2024 оны 02 дугаар сарын 08-ний өдөр зарлаж, 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр нээсэн тус тендер шалгаруулалтын Багц № 7: Нимгэн хавтгай хэрчсэн үхрийн мах-10кг, Багц № 8: Нарийн савхан хэрчиж бэлтгэсэн үхрийн мах-10кг, Багц № 9: Машиндсан мах-Үхэр-10кг, Багц № 10: Нимгэн хавтгай хэрчсэн хонины мах-10кг, Багц № 11: Нарийн гонзгой хэрчсэн хонины мах-10кг, Багц № 12: Машиндсан мах-Хонь 10кг багцуудад 5 аж ахуйн нэгж захиалагчийн тогтоосон нэгж үнийн дээд хязгаарыг хүлээн зөвшөөрч тендерт санал ирүүлсэн бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.10.1 дэх заалт “тендерийн үнэ төсөвт өртгөөс, эсхүл энэ хуулийн 10.11-д заасан болон ерөнхий гэрээний нэгж дээд үнээс хэтэрсэн...”-д заасан нөхцөл байдал үүсээгүй тул тухайн багцуудын нэгж дээд үнийн хязгаарт өөрчлөлт оруулах нөхцөл үүсээгүй болохыг мэдэгдье.

ДАРГА  Ц.БАТЗУЛ

1324023711

ТХААГ-2024-А4

9020026195 СБТ-11261 6529909